



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/5/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цэнгэлмаа Утас: 70350757 Цахим хаяг: tsengelmaaj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 93
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ ЦЭЦЭРЛЭГТ
ХҮРЭЭЛЭНГИЙН АШИГЛАЛТЫН
ӨМНӨХ ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ
М.ЭНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь Орхон аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/149 дүгээр захирамжаар 14,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, үлдэх өртөггүй болсон Тоёото Кроун маркийн автомашиныг шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа нь тайлант онд 12 иргэд болон аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн эзэмшлийн талбайг түрээслүүлэх гэрээ хийж, 3,550.0 мянган төгрөгийг Эрдэнэт санд төвлөрүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13,063.42	15,939.87
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.6	Бараа материал	345,900.00	1,107,949.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	7,370,000.00	13,945,900.00
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,728,963.42	15,069,788.87
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,631,169,524.37	4,906,583,945.37
1.2.2	Биет бус хөрөнгө	1,200,000.00	1,200,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл	(408,727,990.24)	(683,409,842.01)
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,223,641,534.13	4,224,374,103.36
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,231,370,497.55	4,239,443,892.23
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: А) Төрийн	4,649,787,715.75	4,911,202,136.75
2.3.2	Б) Хувийн	-	-
2.3.3	В) Хувьцаат	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(267,876,768.12)	(253,341,026.32)
2.3.10	Өмнөх үеийн үр дүн	(150,540,450.08)	(418,417,218.20)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн үр дүн	4,231,370,497.55	4,239,443,892.23
2.4	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,231,370,497.55	4,239,443,892.23

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг /алдагдал/	-	-
4	Түрээсийн орлого	-	-
7	Бусад орлого	164,588,900.00	203,573,100.00
8	Бусад орлого	6,793,500.00	-
9	Борлуулалт маркетингийн зардал	3,537,000.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	-
11	Санхүүгийн зардал	122,784,147.59	148,110,506.85
12	Бусад зардал /Элэгдлийн зардал/	45,712,114.19	48,121,767.70
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	237,224,654.40	260,681,851.77
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-

15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(37,075,251.94)	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(267,876,768.12)	(253,341,026.32)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг /алдагдал/	(267,876,768.12)	(253,341,026.32)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(267,876,768.12)	(253,341,026.32)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,649,787,715.75	(418,417,218.20)	4,231,370,497.55
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
3	Залруулсан үлдэгдэл	4,649,787,715.75	(418,417,218.20)	4,231,370,497.55
4	Тайлант үеийн ашиг/алдагдал		(267,876,768.12)	(267,876,768.12)
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт	261,414,421.00		
7	Зарласан ногдол ашиг			
8	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,911,202,136.75	(671,758,244.52)	4,239,443,892.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	164,588,900.00	203,573,100.00
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	164,588,900.00	203,573,100.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Татаас, санхүүжилтийн орлого	164,588,900.00	203,573,100.00
	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	168,123,361.78	203,570,223.55
	Ажилчдад төлсөн	110,400,495.00	131,812,027.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,583,652.59	16,298,479.85
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	14,672,791.00	14,747,608.00
	Бичиг хэрэг	1,962,300.00	1,357,050.00
	Ашиглалтын зардалд төлсөн	20,888,643.19	28,564,458.70
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,737,000.00	7,415,100.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	1,878,480.00	3,315,500.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,538.22	2,876.45
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		

3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,538.22	2,876.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,525.20	13,063.42
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,063.42	15,939.87

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Тайлант оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	131,812,800.00	131,812,027.00	773.00
	Үндсэн цалин	119,829,800.00	108,631,513.00	11,198,287.00
	Нэмэгдэл	11,983,000.00	23,180,514.00	(11,197,514.00)
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,296,600.00	16,298,479.85	(1,879.85)
	Тэтгэврийн даатгал	11,204,100.00	11,204,024.74	75.26
	Тэтгэмжийн даатгал	1,318,100.00	1,318,132.17	(32.17)
	ҮОМШӨ-ний даатгал	1,054,500.00	1,054,499.79	0.21
	Ажилгүйдлийн даатгал	263,600.00	247,438.34	16,161.66
	Эрүүл мэндийн даатгал	2,456,300.00	2,474,384.81	(18,084.81)
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,584,000.00	26,587,084.70	(3,084.70)
	Гэрэл, цахилгаан	25,000,000.00	26,158,084.70	(1,158,084.70)
	Цэвэр, бохир ус	1,584,000.00	429,000.00	1,155,000.00
4	Хангамж, бараа материалын зардал	17,485,700.00	17,485,632.00	68.00
	Бичиг хэрэг	720,000.00	1,357,050.00	(637,050.00)
	Тээвэр, шатахуун	3,744,000.00	2,400,000.00	1,344,000.00
	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,140,000.00	1,017,374.00	122,626.00
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	960,000.00	840,000.00
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,081,700.00	11,751,208.00	(1,669,508.00)
5	Норматив зардал	1,880,000.00	1,872,400.00	7,600.00
	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,880,000.00	1,872,400.00	7,600.00
6	Эд хогшил, урсгал засварын зардал	6,200,000.00	6,199,100.00	900.00
	Багаж, техник, хэрэгсэл	-	1,079,000.00	(1,079,000.00)
	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,200,000.00	45,000.00	1,155,000.00
	Урсгал засвар	5,000,000.00	5,075,100.00	(75,100.00)
7	Томилолт, зочны зардал	350,000.00	350,000.00	-
	Дотоод албан томилолт	350,000.00	350,000.00	-
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,764,000.00	1,765,500.00	(1,500.00)
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	960,000.00	998,800.00	(38,800.00)
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-
	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84,000.00	46,700.00	37,300.00
9	Урсгал шилжүүлэг	1,200,000.00	1,200,000.00	-
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	-
	Нийт	203,573,100.00	203,573,100.00	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,527.0 төгрөгийн алдаа¹ илэрснээс 1,527.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 14,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

Албан хаагчийн ээлжийн амралттай байх хугацаанд нийт 2 хоногийн цалинг давхардуулан олгосон, тайлант хугацаанд талбай түрээслүүлсэн орлогыг "Эрдэнэт сан"-д бүрэн төвлөрүүлээгүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", Орон нутгийн өмчийн түрээсийн гэрээний 4.3-д "Түрээсийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй." гэж заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитаар илрүүлсэн алдаа зөрчилд албан шаардлага тогтоогоогүй болно.

3.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийг шилжүүлэн авахдаа үлдэх өртгөөр бус анхны өртгөөр бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:", 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт.", НББОУС-16 Үндсэн хөрөнгө "Хөрөнгийн арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртгийг тэрхүү олж эзэмшилтийн өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ.", гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусган авахдаа тухайн өдрийн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа	1	1,450.0	1	1,450.0								
Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа	1	77.0	1	77.0								
Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа	1	14,000.0					1	14,000.0				
Дүн	3	15,527.0	2	1,527.0			1	14,000.0				

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ТБОНӨҮГ		1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ		1			1			

